

Увс аймгийн Өмнөговь сум

**“ТӨРӨЛХ НУТГАА  
ХӨГЖҮҮЛЬЕ”**

**2020 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД  
АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРАЛД БИЕ ДААН НЭР ДЭВШИХ  
ДЭРЧИН ОВОГТОЙ ДАВААСҮРЭНГИЙН  
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**2020 он**

## **Уриа: “Төрөлх нутгаа хөгжүүлэе”**

### **Нэг. Нийгмийн бодлогын хүрээнд**

1. “Ахмад, дунд, залуу” гурван үеийн алтан хэлхээг хангаж, ахмадаасаа суралцаж, дунд үеийнхэн хүчтэй хөдөлмөрлөж, залуу үеэ халамжлан хүмүүжүүлэх замаар сумаа хөгжүүлэх үйлсэд иргэдийнхээ оролцоог тэгш хангах бодлого баримтлана.
2. “Сумандаа сайхан амьдаръя” төсөл санаачилж, иргэдийнхээ ая тухтай, эмх цэгцтэй ажиллаж амьдрах нөхцөлийг хангах бодлого хэрэгжүүлж ажиллана.
3. Хүүхдийн “Хөдөлмөр” амралтын зусланг сэргээн хөгжүүлж, амьдрах ухаан, мал аж ахуй эрхлэх монгол ахуйд суралцуулна.
4. Ахмад, эмэгтэйчүүд, залуучууд, хүүхдүүд болон төрийн албан хаагчдын уулзалтыг үе шаттай зохион байгуулж, тэднээс гаргасан зөв зүйтэй санал, санаачилгыг дэмжиж сумын хөгжлийн бодлого, зорилтод тусгаж хэрэгжүүлж ажиллана.
5. Төрийн үйлчилгээний байгууллагуудын ажлын уялдаа холбоо, иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад анхаарч төрийн албанд мэдлэг, чадвартай боловсон хүчнийг сонгож, томилдог болох зарчмыг хэрэгжүүлж, төрийн байгууллага, албан тушаалтанд хяналт тавьж ажиллана.
7. Сумын иргэд, ялангуяа малчдыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд тогтмол хамруулах ажлыг тухай бүр хийж байх бодлого хэрэгжүүлнэ.

### **Хоёр. Эдийн засгийн бодлогын хүрээнд**

1. Хууль, журмыг зөрчиж ах дүү, танил тал, нам, баг болон тойрон хүрээлэгчдээ дэмжиж төсөл, тендер өгдөг явдлыг таслан зогсоож, хийж бүтээе, ажлын байр нэмэгдүүлье гэсэн иргэн, ААН-д төсөл, тендерийг олгодог болох бодлого барьж, үр ашигтай жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ.
2. Дотоодын аялал жуулчлал эрчимтэй хөгжиж байгаа энэ үед сумын аялал жуулчлалын маршрут гарган түүх, соёлын дурсгал, байгалийн үзэсгэлэнт газруудаа жуулчдад үзүүлж сонирхуулах замаар малчид, аж ахуйн нэгж, иргэд орлого олох боломжийг бүрдүүлнэ.
3. Малын гаралтай түүхий эд /арьс, шир, ноос ноолуур/-эд суманд анхан шатны боловсруулалт хийж, түүхийн эдийн үнэ ханшийг нэмэгдүүлэхээр зорьж байгаа иргэн, ААН-ийн үүсгэл, санаачилгыг бодлогоор дэмжинэ.

### **Гурав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд**

1. Малын эрүүл мэнд, чанарыг сайжруулах, вакцин, эм тариаг цаг хугацаанд нь чанар, хүртээмжтэй хийлгэх, мал угаалгын ванныг илүү боловсронгуй болгоход анхаарч, мал эмнэлэг, үржлийн нэгжүүдийн ажлын тайланг малчдад тавиулж хэвшинэ.
2. Мал цөөтэй өрх болон мал маллах сонирхолтой залуу малчин өрхийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор “Үр дүнтэй малжуулалт” төслийг төр, хувийн хэвшилтэй хамтарч хэрэгжүүлэхийг зорино.
3. “Хар хаг”-ийн услалтын системийг сэргээж, усалгаатай газар тариаланг хөгжүүлэн, малын тэжээлийн үйлдвэр, цехтэй болох ажлыг эхлүүлж, зарим багуудыг хадлангийн талбайтай болгох тал дээр анхаарна.
4. Аймгийн аварга малчинд тодорхойлох, сумын аварга малчин шалгаруулж шагнадаг журмыг илүү боловсронгуй болгоход анхаарч, тухайн багийн ИНХ-аар хэлэлцэгдэж, олонхийн дэмжлэг хүлээсэн хүнийг аймаг, сумын аваргаар шалгаруулж, хөдөлмөр зүтгэлийг зөв бодитоор үнэлэх тогтолцоог бий болгоно.

## **Дөрөв.Аймгийн түвшинд**

1. Хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлуудыг аймгийн ИТХ-аас ажлын хэсэг байгуулан МХГазар, иргэдийн төлөөлөлтэй хамтран хамтын хяналт тавих нөхцөл бололцоог судлаж шийдвэрлүүлнэ.
2. Ажлын байр бий болгох, иргэдийн амьжиргааг дэмжих чиглэлийн төсөл хөтөлбөрүүдийг бүх талаар дэмжиж ажиллана.
3. Аймгийн орон нутгийн хөгжил сангийн хөрөнгийг үр дүн багатай жижиг ажлуудыг санхүүжүүлж ирсэн байдалд дүгнэлт хийж бодитой үр дүн өгөх мал аж ахуйн түүхий эд боловсруулдаг жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх үүсгэл санаачлагыг дэмжиж ажиллана.
4. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн үйл ажллагаанд дэмжлэг үзүүлэх чиглэлийн арга хэмжээнүүдийг бүх талаар дэмжиж ажиллана.
5. Дэлхий дахинд нүүрлэж буй эдийн засгийн хямралын үед иргэдээ ядуурлаас аврах бүх талын санал санаачлагыг дэмжиж ажил хэрэг болгох талаар өөрийн бололцоог дайчлан ажиллана.
6. Төрийн албанд ажиллаж байгаа шилдэг албан хаагчдийг дэмжих тэдний арга туршлагыг түгээн дэлгэрүүлэх талаар санаачлага гаргаж ажиллана.